

Увс аймагт тарваган тахлын байгалийн голомтын тандалт судалгаа хийлээ

2025

ЗӨСҮТ, Эрхүү хот дахь Сибирь, Алс Дорнодын тарваган тахал эсэргүүцэн суглах эргэм шинжилгээний хүрээлэн, Увс аймгийн Зоонозын өвчин судлалын төв (ЗӨСТ)-тэй хамтран “Монгол Улс, ОХУ-ын хил орчмын бүс гэх тарваган тахлын байгалийн голомтын орчин үеийн байдал” сэдэвт хамтын ажиллагааны гэрээ (2022-2024)-ний хүрээнд 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөс 07 дугаар сарын 12-ны өдрүүдэд тарваган тахлын байгалийн голомтын төлөв байдлыг тогтоох хээрийн хайгуул - тандалт судалгааг Увс аймгийн Сагил, Бөхмөрөн сумдын нутагт зохион байгууллаа.

Судалгааны ажлын үр дүн

Хээрийн судалгаагаар 5 зүйлийн 142 амьтан олзворлож, 56 зэм үхдэл, 19 гулгигас (100 сорьц), амьтдын үс ноолуураас самналтаар 441 бүүрэг, 85 хачиг, 2 бөөс, нүхний амсраас 22 бүүрэг, 8 хачиг тус тус цуглуулж, нийт 856 нэгж материалыг лабораторийн шинжилгээнд хамруулсан.

Судалгаанд хамрагдсан талбайд “Монгол тарвага” жигд тархалттай байсан бөгөөд галайн түвшнээс дээш 2150-2800 метрийн өндөрт уулын ар, өвөр, бэл, салаа хөндий, уулын энгэр газруудад 1 га талбайд гунджаар 2.94 нягтшилтай бүртгэгдэв.

2024 онтой харьцуулахад тарваганы нягтшил 0.33%-иар, огдойн нягтшил 1.22%-иар тус тус өссөн бол, зурмын нягтшил 1.5%-иар буурсан байна.

Мэрэгч болон туулай хэлбэртний үс, ноолуураас нийт 142 ширхэг гадны шимэгч цуглуулж, 14 зүйлийн бүүрэг тогдорхойлсон.



Лабораторийн шинжилгээний дүн

Хээрийн нөхцөлд GAZ-33027 /Газель/ маркийн авто лабораториг Rotor Gene Q богиом цагийн ПГУ аппаратаар тарваган тахал болон хулгана тахлын үүсгэгч илрүүлэх шинжилгээ хийж, бүх сорьцог сөрөг гүн гарсан.

Мөн сорьцыг ЗӨСҮТ-ийн төв лабораториг зөөвөрлөн авчирч хуурмаг сүрьеэ, ям, хуурмаг ям, листериоз, эризипелоз, пастерелмёз өвчний молекул биологийн шинжилгээ хийхэд бүгд сөрөг хариу гарсан байна.

Махчин шувуудын бөөгнөрөл бага, лабораторийн шинжилгээгээр эерэг сорьц илрээгүй тул голомтын идэвхжил тайван (гөлгөөн) түвшинд байна гэж үнэлэв.

Мэдээлэл, сургалт, сурталчилгаа

Судалгааны хүрээнд Бөхмөрөн, Сагил сумдын нийт 110 иргэнийг асуумж судалгаанд хамруулж, 310 айл өрхөд тарваган тахал өвчний талаар гараах сэдвүүдээр сургалт зохион байгуулан ажилласан. Үүнд:

- Байгалийн голомт, эх уурхай,
- Халдвар дамжих зам,
- Эмнэл зүйн шинж тэмдэг,
- Өвдсөн тохиолдолд хаана хангах,
- Урьдчилан сэргийлэх арга хэмжээ,
- Үхсэн болон нохой барьсан тарвага тааралдвал мэдгээлэх байгууллагын талаар мэдгээлэл, сургалт зохион байгуулаа.

Мөн зоонозын халдварт өвчний гарын авлага, зурагт хуудас 150 ширхгийг тараан ажилласан.

Судалгааны дүнгээр тарваган тахал өвчний талаарх иргэдийн мэдлэгийн түвшин 70 хувь буюу "Дунд" үнэлгээтэй гарч, эрсдэл үнэлэх асуумжаар иргэдийн гадал, хандлагад эерэг өөрчлөлт ажиглагдаж, эрсдэлд өртөх магадлал буурсан байна.

